



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН  
ТУШААЛ

2015 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/184

Улаанбаатар хот

Дүрэм, журам батлах тухай

Ректорын зөвлөлийн 2015 оны 06-р сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм”-ийг нэгдүгээр хавсралтаар, “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм”-ийг 2015 оны 09-р сарын 01-нээс нийт багш, ажилтны үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Боловсрол эрхэлсэн проректор Х. Энхжаргалд зөвлөмж болгосугай.

3. “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм” батлагдсантай холбогдуулан сургуулийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д дараах өөрчлөлтийг оруулсугай.

- a. 10.1 дэх заалтын “Багшийн мэргэжлийн ёс зүйн дүрэм” гэснийг “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм” гэж
- b. 10.4.2 дахь заалтын “Багшийн мэргэжлийн ёс зүйн зөвлөл” гэснийг “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөл” гэж

4. “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм” батлагдсантай холбогдуулан багш, ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд зохих заалтыг тусгахыг Захиргаа, мониторингийн газрын дарга /Л. Пүрэв/-т даалгасугай.

5. Дээрх дүрэм, журам батлагдсантай холбогдуулан Ректорын 2007 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 273 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

РЕКТОР



Б. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН БАГШ, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн багш, ажилтны ёс зүйн дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хөдөлмөрийн хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, ШУТИС-ийн дотоод дүрэм журам, хамтын гэрээнд заасан зохицуулалт болон энэхүү ёс зүйн хэм хэмжээгээр тодорхойлогдоно.
- 1.2. Энэхүү дүрмийн эрхэм зорилго нь их сургуулийн хэмжээнд сургалт, эрдэм шинжилгээ, болон нийгэмд үйлчлэх үйлчилгээ, хүний эрх, эрх чөлөө, үнэ цэн, тэдгээрийг хүндэтгэх, багш, ажилтан, удирдах ажилтны үйл ажиллагаандаа дагаж мөрдөх ёс зүйн хэмжээг тогтоон хэвшүүлэх үндсэн чиг үүргээ нэр төртэй, хариуцлагатай, хэлбэрэлтгүй биелүүлэхийн тулд нийтлэг үнэт зүйлс, ёс суртахууны зарчим, хэм хэмжээг мөрдлөг болгоход оршино.
- 1.3. Багш, ажилтан, удирдах ажилтан нь нийгэм, сургууль, хамт олонд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, эдлэх эрх чөлөө, эзлэх байр суурийн харилцан уялдаа холбоог зохицуулах нь энэхүү дүрмийн үндэс юм.
- 1.4. Энэхүү дүрэм нь их сургуулийн хэмжээнд одоо ажиллаж байгаа нийт багш, ажилтан, удирдах ажилтанд хамаарна.
- 1.5. Багш гэдэгт их сургуулийн хэмжээнд багшийн албан тушаалд ажиллаж байгаа болон тус сургуульд гэрээт, цагийн, зөвлөхөөр багшилж буй профессор багш нар хамаарна.
- 1.6. Ажилтан гэдэгт их сургуулийн хэмжээнд ажиллаж байгаа төв болон салбарын захиргаа, сургалт, эрдэм шинжилгээ, санхүү, гадаад харилцаа, номын сан, оюутанд үйлчилгээ үзүүлэх бүх шатны нэгжүүдийн мэргэжилтэн, ажилтан, ажилчин хамаарна.
- 1.7. Удирдах ажилтан гэдэгт шийдвэр гаргах эрх бүхий ректор, проректор, газар, албадын дарга, орлогч, бүрэлдэхүүн сургууль болон бусад нэгжүүдийн захирал, дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, салбар болон тэнхимийн эрхлэгч нар хамаарна.
- 1.8. ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн зөвлөл нь их сургуулийн хэмжээнд багш, ажилтан, удирдах ажилтны ёс зүйн асуудлыг эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах үүргийг гүйцэтгэнэ.

### Хоёр. Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- 2.1. Хуулиар олгогдсон эрхээ эдлэх, хэрэгжүүлэхдээ бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн хүндэтгэнэ.
- 2.2. Хүн бүр итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх суурь эрх чөлөөг эрхэмлэн хүндэтгэнэ.
- 2.3. Дээд боловсролын байгууллагын үндсэн зорилгууд болох мэдлэг олгох, сурч боловсрох эрх ашгийг урьтал болгох, судалгааны ажлын эрх чөлөөг хүндэтгэх, мэргэжлийн үнэ цэнийг хамгаалах, нийгмийн хариуцлагыг ухамсарлан хүн бүрт



хүртээмжтэй, аюулгүй, эрүүл таатай орчинд ажиллах суралцах боломж олгохыг эрмэлзэнэ.

- 2.4. Хувийн үзэл бодол, итгэл үнэмшил, шашин, улс төр, днийгмийн байр сууриа суралцагч, хувь хүн, хамт олонд шууд болон шууд бусаар тулган хүлээлгэх, нөлөөлөхгүй байна.
- 2.5. Багш ажилтантай холбоотой ёс зүйн санал гомдлыг тухайн харьяалагдаж байгаа шат шатны нэгжүүдээр хэлэлцүүлнэ.
- 2.6. Удирдах ажилтантай холбоотой ёс зүйн санал гомдлыг тухайн удирдах ажилтны шууд удирдлагад гаргана.

### **Гурав. Багш, ажилтан, удирдах ажилтны баримтлах ёс зүйн хэмжээ**

#### **3.1. Нийтлэг дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ:**

- 3.1.1. Суралцагч, хувь хүн, хамт олныг үг хэлээр гутаан доромжлох, дорд үзэх, бусдын нэр хүндийг унагаах үйлдэл гаргахгүй байх
- 3.1.2. Суралцагч, хувь хүн, хамт олны нууцтай холбоотой мэдээллийг хууль бусаар ашиглах, бусдад дамжуулахгүй байх
- 3.1.3. Мэргэжил, албан тушаалын давуу талаа ашиглан суралцагч, хувь хүн, хамт олныг боловсролын байгууллагын үндсэн үүргээс гадуур харилцаанд орохыг тулгах, шаардахгүй байх
- 3.1.4. Өөрийн давуу байдлаа ашиглан бусдыг бие махбодь, сэтгэл зүй болон санхүүгийн дарамтанд оруулахгүй байх
- 3.1.5. Албан тушаалын байдал, эрх мэдлээ ашиглан хувьдаа ашиг хонжоо, давуу тал олох, бий болгохгүй байх.

#### **3.2. Багшлах үүргээ хэрэгжүүлэх ёс зүйн хэм хэмжээ:**

- 3.2.1. Багш оюутандаа бие даан, бүтээлчээр суралцах чадвар эзэмшүүлэхэд анхаарч, тэдний суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- 3.2.2. Багш оюутанд хувь хүнийх нь хувьд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ харилцааны өндөр соёлтой байж тэдний сурах үйл ажиллагааг чиглүүлэн удирдагч, зөвлөгч нь байна.
- 3.2.3. Багш, оюутны хоорондын харилцаанд харилцан хүндэтгэлийг эрхэмлэж, багш оюутанд зөв үлгэр дуурайллыг үзүүлнэ.
- 3.2.4. Багш нь оюутны сургалтын ажил, кредитийн биелэлт, сахилга бат, соёлч байдал, үндэсний уламжлал, ёс суртахууны төлөвшлийн асуудлаар зөвлөн ажиллана.
- 3.2.5. Багш хичээлийн хөтөлбөрийг агуулга, арга зүй, үр дүнг үнэлгээний өндөр түвшинд хэрэгжүүлнэ.
- 3.2.6. Багш, оюутны мэдлэг чадварыг бодитой, шударга дүгнэж үнэлнэ.

#### **3.3. Багшлах үйл ажиллагаанд хориглох ёс зүйн хэм хэмжээ:**

- 3.3.1. Оюутныг үндэс угсаа, хэл, нас хүйс, шашин шүтлэг, үзэл бодол, амьдралын нөхцөл, хөгжлийн онцлог байдал болон хувийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, тэгш бус хандах

- 3.3.2. Зөвлөх багшийн үүргээ биелүүлэхгүй байх
  - 3.3.3. Албан тушаал, эрх мэдлээ ашиглан дур мэдэн эсхүл хувийн шалтгаанаар оюутны санал бодол, ухамсарт хүчээр нөлөөлөх, үзэл бодлоо тулгах, аашилж загнах, айлган сүрдүүлэх зэргээр зүй бус авирлах
  - 3.3.4. Оюутны бие махбодид халдах, сэтгэл санааны дарамт учруулах
  - 3.3.5. Оюутнаас мөнгө нэхэх, ном бүтээгдэхүүн худалдаж авахыг тулгах, хуульд заагаагүй төлбөр, хураамж оюутнаас авах
  - 3.3.6. Оюутны хувийн нууцыг задруулах
  - 3.3.7. Оюутныг өөрийнэрх ашиг, сонирхлын үүднээс ажиллуулах
  - 3.3.8. Хичээл, шалгалт, ажлын цагийн хуваарийг зөрчих
  - 3.3.9. Хичээл дээр улс төр, шашны ухуулга, сурталчилгаа хийх
  - 3.3.10. Хичээлд холбогдолгүй материалыг сургалтанд ашиглах
  - 3.3.11. Оюутны мэдлэг, чадварыг үнэлэхдээ багш өөрийн тухайн үеийн сэтгэлийн хөдөлгөөн, оюутны хувийн зан чанар, нийгмийн болон биеэ авч явах байдлын талаар төрсөн сэтгэгдэлдээ тулгуурлах
  - 3.3.12. Оюутны мэдлэгийг үнэлэх үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор тэдний үйл ажиллагаанд хайнга хандах, зайлшгүй эзэмших зүйлийг хийж гүйцэтгүүлэхгүй орхигдуулах, эсвэл хэт их ачаалал үүсгэх
  - 3.3.13. Шалгалтын материалыг зориуд болон санамсаргүйгээр задлах
  - 3.3.14. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оюутанд хичээл заахаас татгалзах, хичээлд оруулахгүй байх.
- 3.4. Багшийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэх ёс зүйн хэм хэмжээ:
- 3.4.1. Багш нь мэдлэг боловсрол, заах арга зүй, эрдэм судлалын ажлын чадвараа байнга дээшлүүлж, мэргэжлийн өндөр ур чадвартай байна.
  - 3.4.2. Багш хамтран ажиллагч багш нартайгаа өөрийн мэдлэг, туршлагыг хуваалцан, тэднээс мэргэжлийн хувьд суралцахыг эрхэмлэн ажиллана.
  - 3.4.3. Багшийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхэд хориглох ёс зүйн хэм хэмжээ:
    - 3.4.3.1. Бусдын зохиол бүтээл, судалгаа, нээлтийг санаатайгаар хууль бусаар өөрийн болгох
- 3.5. Багшийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ёс зүйн хэм хэмжээ:
- 3.5.1. Багш бүтээлч байж, ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд санаачлагатай, шударгаар биелүүлнэ.
  - 3.5.2. Багш сургуулийн дүрэм, журам, заавар, ректорын тушаал, шийдвэрийг баримтална.
  - 3.5.3. Багш ажил үйлчилгээгээ түр буюу бүрмөсөн зогсоох тохиолдолд мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд энэ шийдвэр хэрхэн нөлөөлөхийг ухамсарлаж, холбогдох албан тушаалтанд урьдчилан мэдэгдэнэ.
  - 3.5.4. Багшийн үйл ажиллагаанд хориглох ёс зүйн хэм хэмжээ:
    - 3.5.4.1. Сургуулиас санаачилсан, зохион байгуулсан ажил, үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулах
    - 3.5.4.2. Сургуулийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр хувийн болон арилжаа, улс төр, шашны зорилгоор ашиглах
    - 3.5.4.3. Сургуулийн бусад багш, ажилтныг үүрэгт ажлаа гүйцэтгэхэд нь саад учруулах, заналхийлэх буюу дарамтлах
    - 3.5.4.4. Багшийн мэргэжлийн ёс зүйн талаар сургуулиас баримталж буй бодлогыг зөрчих

- 3.5.4.5. Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, ажилдаа согтуу ирэх
- 3.5.4.6. Хувийн үзэл бодлоо санаатайгаар сургууль, түүний нэгжийн байр суурь хэмээн ойлгуулах

- 3.6. Багш, хамт ажиллагчидтайгаа харилцахад хэрэгжүүлэх ёс зүйн хэм хэмжээ:
  - 3.6.1. Багш хамт ажиллагчидтайгаа хүндэтгэлтэй харилцаж, ажил хэрэгч бодит санал шүүмжлэлийг хүлээн авч, аливаа асуудлыг эв зүйгээр шийднэ.
  - 3.6.2. Хамт ажиллаж байгаа хүмүүсийн эрдмийн эрх чөлөөг хүндэтгэнэ.
  - 3.6.3. Багш, сургах хүмүүжүүлэх үүргээ ухамсарлан, хамтран ажиллагчдын талаар мэргэжлийн бодитой дүгнэлт, үнэлэлт өгнө.
  - 3.6.4. Сургууль, хамт олны удирдлагын үйл ажиллагаанд багш өөрийн санал, бодлыг ил тод илэрхийлж, оролцоно.
  - 3.6.5. Багшийн харилцаанд хориглох ёс зүйн хэм хэмжээ:
    - 3.6.5.1. Хамт ажиллагчдын мэргэжлийн, мөн хувийн зан чанарын дутагдлын талаар оюутнуудтай болон тэдний дэргэд ярилцах
    - 3.6.5.2. Бусад багш нарыг ажил үүргээ гүйцэтгэх явцад хөндлөнгөөс нөлөөлж, өөрийн үзэл бодлоо тулгах, оюутны үнэлгээг заах
    - 3.6.5.3. Хувь хүний болон байгууллагын нууцын хууль тогтоомжийг зөрчих
    - 3.6.5.4. Бусад багшийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн онцлог болон хувийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, тэдэнд тэгш бус хандах

#### **Дөрөв. Ажилтан, удирдах ажилтны баримтлах ёс зүйн хэмжээ**

- 4.1. Ажилтан, удирдах ажилтанд үүрэг болгосон хэм хэмжээ:
  - 4.1.1. Үүрэгт ажлаа хариуцлагатай, идэвх санаачлагатай гүйцэтгэх
  - 4.1.2. Ажлын цаг баримталж, үр өгөөжтэй, бүтээлч ашиглах
  - 4.1.3. Мэдээллийг нээлттэй, ил тод, тогтмол байлгаж, ШУТИС-ийн багш, ажилтанд шаардлагатай, хүссэн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх
  - 4.1.4. ШУТИС-ийн багш, ажилтан болон тэдний төлөөллөөс тавьж буй шүүмжлэл, шаардлага, өргөдөл, гомдлыг бодит үндэслэлтэй, тэгш, шударга шийдвэрлэх
- 4.2. Ажилтан, удирдах ажилтанд хориглосон ёс зүйн хэм хэмжээ:
  - 4.2.1. Хувийн ашиг сонирхлын үүднээс сургуулийн бизнесийн үйл ажиллагаанд ямарваа нэг санал тавих, мэдээлэл, сурталчилгаа хийх, зөвшөөрөл олгох, шийдвэр гаргах
  - 4.2.2. Үүрэгт ажлаа хувийн ашиг сонирхолтой хольж хутгах, эсвэл бусдад тийм хардлага төрүүлэх нөхцөл байдал үүсгэх
  - 4.2.3. Боловсон хүчнийг ажилд авах, албан тушаалд дэвшүүлэх, ажилд томилох, шагнал урамшуулалд тодорхойлох, мэргэжил дээшлүүлэхэд ашиг сонирхлын зөрчил гаргах, ил тод байдлыг үл хангах
  - 4.2.4. Эрх мэдлээ урвуулан ашиглаж тодорхой хүмүүст давуу боломж олгох, дэмжлэг үзүүлэх
  - 4.2.5. Мэргэжлийн эсвэл шинжээчийн байр сууринаас олон нийтэд хандах тохиолдолд их сургуулийн ажилтны нэрийг ашиглаж болох боловч хувийн бодол, үнэлэлт, дүгнэлт гэдгээ үл онцлох
  - 4.2.6. Урьдчилан зохих зөвшөөрөл авалгүйгээр сургуулийн нэр ашиглан бараа бүтээгдэхүүний реклам, сурталчилгаа хийх



- 4.2.7. Ажлын цагаар хувийн ажил хийх
- 4.2.8. Ажил мэргэжилд өрсөлдөж байгаа хүний мэдээг, чадварын талаар санаатай худал мэдүүлэг гаргах.
- 4.3. Ажилтан, удирдах ажилтны ёс зүйн тусгай хэм хэмжээ
  - 4.3.1. Удирдах ажилтан
    - 4.3.1.1. Боловсролын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд идэвх санаачлагатай, манлайлагч байх
    - 4.3.1.2. Сургууль, бүрэлдэхүүн сургууль, нэгжийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, бодлого боловсруулах чадвартай байж, түүний хэрэгжилт, явц, үр дүнд анхаарч ажиллах, бүтээлч, хариуцлагатай байх
    - 4.3.1.3. Удирдах арга барил, хууль эрх зүй, менежментийн мэдлэг, чадвараа байнга дээшлүүлж, сургуулийн хөгжил цэцэглэлтэд бодитой хувь нэмэр оруулах
    - 4.3.1.4. Сургалт, эрдэм шинжилгээний түвшинг орчин үеийн хөгжлийн шаардлага, шинжлэх ухаанч академик чиг хандлагатай нийцүүлэн шинэчилж байх
    - 4.3.1.5. Сургуулийн багш, ажилтан, ажилчид, суралцагчдын идэвх санаачлагыг өрнүүлж, бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх
    - 4.3.1.6. Сургууль, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгохгүй байх
    - 4.3.1.7. Аливаа шийдвэрийг сургууль, хамт олны эрх ашгийн үүднээс ухаалаг, зүй зохистой, үндэслэлтэй гаргах, шийдвэрийн үр дүнд хяналт тавих
    - 4.3.1.8. Аливаа тендер, сонгон шалгаруулалт, худалдах, худалдан авах, боловсон хүчнийг сонгох, дэвшүүлэх зэрэгт өөрийн хамаатан садан, хувийн ойр дотно харилцаатай найз нөхдийг дэмжих, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх
    - 4.3.1.9. Хувийн болон хамаатан садан, ойр дотно харилцаатай хүмүүст бизнесийн шууд ба шууд бус ашиг олгох боломжийг бүрдүүлэхгүй байх
    - 4.3.1.10. Сургуулийн эд хөрөнгийг хувийн ашиг сонирхлоор бусдад ашиглуулахгүй байх
  - 4.3.2. Ажилтан, ажилчин
    - 4.3.2.1. Ажил, үүрэгтэй холбоотой мэдээлэл олж авах боломжийг нээлттэй байлгах;
    - 4.3.2.2. Сургуулийн удирдлага, багш, ажилтан, ажилчид, суралцагчдад холбогдох үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй, чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх
    - 4.3.2.3. Сургуулийн байр, техник тоног төхөөрөмж, сургалтын хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, эд зүйлс, оюуны бүтээлийг зүй зохистой, гамтай ашиглах
    - 4.3.2.4. Албан тушаалаа урвуулан ашиглахгүй байх.

**Тав. Багш, ажилтан, удирдах ажилтны ёс зүйн зөрчил гаргагчдад хүлээлгэх хариуцлага**


- 5.1. Багш, ажилтан, удирдах ажилтан ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд түүнд холбогдох хууль тогтоомж, сургуулийн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.
- 5.2. Багш, ажилтан, удирдах ажилтны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн багш, ажилтан, удирдах ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн зөвлөлөөр хэлэлцэж, саналаа эрх бүхий албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

ШУТИС-ийн ректорын 2015 оны 08 дүгээр сарын 16-ний  
өдрийн 4137 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

### Зургаа. Бусад

- 6.1. ШУТИС нь Багш, ажилтны ёс зүйн зөвлөлтэй байна.
- 6.2. ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм, Багш, ажилтны ёс зүйн зөвлөлийн ажиллах журам батлах, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Ректорын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ.

ШУТИС-ийн ректорын 2015 оны 49 дүгээр сарын 26-ний  
едрийн 1/37 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



## ШУТИС-ИЙН БАГШ, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 ШУТИС-ийн багш, ажилтаны ёс зүйн зөвлөл нь /цаашид Зөвлөл/ их сургуулийн хэмжээнд багш, ажилтны ёс зүйн асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий Ректорын зөвлөлийн дэргэдэх орон тооны бус байгууллага юм.
- 1.2 Зөвлөлийн зорилго нь багш, ажилтны нэр хүнд, эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэхэд чиглэнэ.
- 1.3 Зөвлөл үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Их дээд сургууль, коллежийн багшийн мэргэжлийн ёс зүйн ерөнхий дүрэм, ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ, бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон энэхүү журмын дагуу явуулна.

### Хоёр. Зөвлөлийн эрх, үүрэг

- 2.1 Зөвлөл нь дараах эрхтэй байна:
  - 2.1.1 ШУТИС-ийн хэмжээнд багш, ажилтны ёс зүйн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаа явуулах
  - 2.1.2 ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай мэдээллийг бичгээр хүлээн авах, баримтжуулах
  - 2.1.3 ёс зүйн дүрмийг зөрчсөн багш, ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах тухай саналыг, шалгаж тогтоосон материалын хамт холбогдох эрх бүхий албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх
  - 2.1.4 багш, ажилтныг буруугүй гэж үзвэл түүний эрх ашиг, нэр хүндийг хамгаалах, сэргээх
  - 2.1.5 ёс зүйн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргах
- 2.2 Зөвлөл дараах үүрэг хүлээнэ:
  - 2.2.1 байгууллагын хэмжээнд ёс зүйн дүрмийг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах
  - 2.2.2 ёс зүйн хэм хэмжээний талаар сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
  - 2.2.3 багш, ажилтны ёс зүйтэй холбоотой асуудлаар ирүүлсэн өргөдөл гомдлыг судалж, хэлэлцэх
  - 2.2.4 шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих
  - 2.2.5 Зөвлөлийн үйл ажиллагааны талаар хичээлийн жилд Ректорын зөвлөлийн хуралд 2 удаа, нийт багш нарын хуралд 1 удаа асуудал оруулж, тайлан тавих

ШУТИС-ийн ректорын 2015 оны 08 дүгээр сарын 26-ний  
өдрийн 1/134 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

### Гурав. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагаа

- 3.1 Зөвлөл нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргаас гадна 10 гишүүнтэй байна.
- 3.2 Зөвлөлийн даргыг ШУТИС-ийн ректортомилно.
- 3.3 ШУТИС-ийн Сургалтын бодлого, чанарын асуудал хариуцсан нэгжийн дарга зөвлөлийн гишүүн байх ба бусад гишүүнийг бүрэлдэхүүн сургууль, нэгж, хамт олны хурлаас олонхийн саналаар сонгож, ректорын тушаалаар баталгаажуулна.
- 3.4 Зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага:
  - 3.5.1 тус сургуульд 5-аас доошгүй жил ажилласан
  - 3.5.2 эрх зүйн аливаа зөрчилд холбогдож байгаагүй.
- 3.5 Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.
- 3.6 Зөвлөлийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
  - 3.6.1 зөвлөлийн үйл ажиллагааг удирдлагаар хангах
  - 3.6.2 хурал зарлан хуралдуулах
  - 3.6.3 гишүүдийн ажил үүргийн хуваарь гаргах, батлах
  - 3.6.4 үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, биелэлтэнд хяналт тавих
  - 3.6.5 зөвлөлийн хурлаас гаргасан санал, дүгнэлтийг, холбогдох материалын хамт эрх бүхий албан тушаалтанд уламжилж шийдвэрлүүлэх
- 3.7 Зөвлөлийн орлогч дарга нь зөвлөлийн даргын эзгүй үед түүний чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 3.9 Зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:
  - 3.9.1 хурлын бэлтгэл хангах, тов зарлах
  - 3.9.2 хурлын тэмдэглэл хөтлөх
  - 3.9.3 өргөдөл, гомдол гаргасан талууд болон хариуцлага хүлээгч, холбогдох байгууллагуудад гаргасан шийдвэрийг бичгээр хүргүүлэх
  - 3.9.4 зөвлөлийн үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл боловсруулах
  - 3.9.5 багш, ажилтны ёс зүйтэй холбоотой асуудлыг бүртгэх
  - 3.9.6 Мэдээ, тайлан, албан хэрэг хөтлөлтийг хийх
- 3.10 Зөвлөлийн гишүүн дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:
  - 3.10.1 ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, ёс зүйг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг төлөвлөх, явуулах
  - 3.10.2 зөвлөлийн хурал дээр зарчимч, шударга, байр суурийг чанд баримтлах
  - 3.10.3 зөвлөлийн хурал дээр хэлэлцсэн асуудлын нууцлах шаардлагатай мэдээллийг олон нийтэд зарлахгүй байх

ШУТИС-ийн ректорын 2015 оны 08 дүгээр сарын 26-ний өдрийн 4/184 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

- 3.11 Зөвлөлийн хурал нь ээлжит, ээлжит бус байна.
- 3.11.1 ээлжит хурлыг хичээлийн жилийн эхэнд ба эцэст хийнэ.
- 3.11.2 ээлжит бус хурлыг асуудал хэлэлцэх тохиолдолд зөвлөлийн даргын шийдвэрээр эсвэл гишүүдийн 1/3-ээс доошгүй хувийн саналаар зарлан хуралдуулна.
- 3.12 Гишүүдийн ирц 70% хүрсэн бол хурлыг хүчинтэйд тооцно.
- 3.13 Зөвлөлийн хуралд хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 3.9 Зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтөлж, зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

#### **Дөрөв. Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх**

- 4.1 Өргөдөл, гомдлыг "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх" тухай хуулийн дагуу хүлээн авч шийдвэрлэнэ.
- 4.2 Хамтран гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авахдаа мэдүүлэгчид бүгд гарын үсэг зурсан эсэх, хэрвээ төлөөлөл гарын үсэг зурсан бол, төлөөлөх эрхийг баталгаажуулсан баримт бичиг хавсаргасан эсэхийг шалгаж авна.
- 4.3 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ёс зүйн асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэн зөвлөлийн даргад танилцуулж, хуваарилсан гишүүнд гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.
- 4.4 Өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

#### **Тав. Зөвлөлийн зардал, урамшуулал**

- 5.1 Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг ШУТИС-ийн төсөвт тусган зарцуулна.
- 5.2 Зөвлөлийн гишүүний жилийн ажлын урамшуулал нь ШУТИС-ийн багшийн албан тушаалын нэг сарын цалинтай тэнцэх хэмжээтэй байна.
- 5.3 Зөвлөлийн үйл ажиллагааны төсвийн зарцуулалтыг ШУТИС-ийн СЭЗГ-т тайлагнана.

ШУТИС-ийн ректорын 2016 оны 08 дүгээр сарын 26-ний  
өдрийн 414 тоот тушаалын гуравдугаар хавсралт



ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга  
Зөвлөлийн орлогч дарга  
Зөвлөлийн нарийн бичгийн дарга  
Зөвлөлийн гишүүд:

А.Эрдэнэбаатар - МХТС-ийн салбарын эрхлэгч  
Д.Ганхуяг - СБЧА-ны дарга  
Д.Оюун - ГУУС-ийн профессор  
Б.Бямбагар - ХШУС-ийн салбарын эрхлэгч  
Д.Сүнжидмаа БАС-ийн профессор  
И.Базаррагчаа МТС-ийн ахлах багш  
Б.Даваажав - БХС-ийн ахлах багш  
Д.Цэцгээ - ҮТС-ийн профессор  
Г.Томтогтох - ГХИ-ийн тэнхимийн эрхлэгч  
Р.Төрбат - Е-НИ-ийн тэнхимийн эрхлэгч  
Ж.Арслан - ЭХС-ийн профессор  
Ч.Ганзориг - ДаТС-ийн салбарын эрхлэгч